



# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

ИД-1-17.

Дугаар 3.

Улаанбаатар хот

Дүрэм ба заавар <sup>13-нөв. 1930. ны 140</sup> батлаа <sup>р тогтоолдоор хүчингүй.</sup>

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын түүх мөнэчлэн байгуулалтын музейн фондын дүрмийг баталсугай. /Дүрмийг хавсаргав/
2. Музейн захиргаанаас түүхийн дурсгалт зүйлийг худалдан авах, урамшил шагнал олгох зааврыг баталсугай. /Зааврыг хавсаргав/



УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРГА *Лувсанчоймбол* ЛУВСАНЧОЙМБОЛ  
ХАРИУУЛАГАТАМ НАРИЙН  
БЛЦГИЙН ХАРГА *Донров* ДОНРОВ

Зөвшөөрсөн.....  
 Боловсруулсан.....  
 Нийлсэн.. *Лувсанчоймбол*..  
 6 % цо. Загдмав.

8.

Улаанбаатар хотын АДХГ Захиргааны гишүүдийн  
1968 оны I-р сарын 17-ны өдрийн 3-р тогтоолоор  
батлав.

Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын  
музейн фондын дүрэм.

1. Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музейд байгаа эд өлөг, түүх-соёлын дурсгалт зүйлс нь музейн үзмэр болон эрдэм шинжилгээний хэрэгцээнд зориулагдсан үнэт зүйл бөгөөд улсын халдашгүй өмч мөн.
2. Музейн фондын зүйлүүд нь элдэв гэмтэл, чанар нь муудах явдлаас хамгаалагдсан тохиромжтой нөхцөлд хадгалагдаж байх ёстой.
3. Музейн фондын зүйлүүд нь тус бүрдээ карт ба эрдэм шинжилгээний паспорттай байх бөгөөд тэдгээр нь музейн эрхлэгчид хадгалагдна.
4. Музейн фондод байгаа зүйлс нь тусгай бүртгэлтэй байх бөгөөд төрөл ангиар нарийн эрэмбэтэй байрлагдсан, эрдэм шинжилгээний хэрэгцээнд ашиглахад аль болох дөхөмтэй байвал зохино.
5. Музейн фондод байгаа зүйлийг фондын эрхлэгч улсын өмнө бүрэн хариуцаж байна. Музейн эрхлэгчийн шийдвэргүйгээр фондын зүйлийг байрнаас гадгаш гаргахыг хориглох бөгөөд гаднын хүнийг фондын өрөөнд оруулж үл болно.
6. Фондын зүйлийг музейн даргын шийдвэрээр үзмэрт шилжүүлэх буюу үзмэрсээс фондод шилжүүлэхдээ гагцхүү тусгай актаар гүйцэтгэнэ.
7. Үзмэрт байгаа зүйлс нь фондын нэг хэсэг бөгөөд тусгай бүртгэл паспорт карттайгаар зохих эзэнд хариуцуулсан байна.
8. Фондын зүйлийг гадгаш шилжүүлж үл болно. Харин фондод шинээр нэмэгдэж ирсэн зүйлийг 7 хоногийн дотор бүртгэлд авч зохих карт, паспортыг фондын эрхлэгч ба музейн эрхлэгчээс хамтарч хөтөлбөл зохино.
9. Фондын зүйлийг фондын эрхлэгч 7 хоног дутамд нарийн



2.

шалгаж хадгалалтанд хяналтыг тавьж байна.Музейн захиргаа үе үе шалгаж байх ба жилд I удаа тусгай акт гаргаж чанарын тодорхойлолт хийж хадгалалтын нөхцлийг сайжруулах арга хэмжээ авч байна.

10.Фондын үнэт зүйлийг лац ломбтой буюу цоожтой саванд хадгалж байх ба фондын өрөөний цоож нь давхар байна. I цоожны нэг түлхүүр музейн даргад нөгөө цоожны түлхүүр фондын эрхлэгчид байна.Онгойлгох үед ломбо,лацыг шалгаж байх ба дежур буюу манаа солилцохдоо харилцан шалгаж гарын үсэг зурж хүлээлцэж байна.

11.Фондын зүйл алдаж үрэгдвэл хармуцах хүнээр уг зүйлийг хэвээр олуулах буюу үнийг 3-10 нугалж төлүүлнэ.

12.Фондын өрөөнд гал усны аюулаас хамгаалах урьдчилсан арга хэмжээнүүд бүрэн авагдсан байвал зохино.

13.Энэхүү дүрмийг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурлаар батлах ба өөрчилнө.

-----"

нийлсэн.....  
хянасан.....  
6% цо.Загджав.

10

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх захиргааны гишүүдийн 1963 оны I-р сарын 17-ны өдрийн 3-р тогтоолоор батлав.

Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын Музейд түүх соёлын дурсгалт зүйлийг цугларуулах ба түүхийн дурсгалт зүйлийг хамгаалах, уг ажилд идэвхтэй оролцогсодыг урамшуулан шагнах заавар.

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Улаанбаатар хотын түүх-шинэчлэн байгуулалтын музей нь манай эх орны нийслэлийн түүхтэй холбогдсон эд өлөг, түүх соёлын дурсгалт зүйлийг байгууллага, хамт олон, иргэдийн сайн дурын үндсэн дээр цугларуулна.

2. Музейд цугларуулах эд өлөг, түүх соёлын дурсгалт зүйлүүд нь нийслэлийн түүхтэй хэрхэн холбогдох тухайн нарийн тодорхойлолт бүхий байх шаардлагатай. Харин нийслэлийн түүхэнд холбогдолгүй зүйлийг музейд цугларуулах хэрэгцээгүй болно.

### ХОЁР. МУЗЕЙД ЦУГЛАРУУЛБАЛ ЗОХИХ ЭД ӨЛӨГ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛҮҮД.

#### 1. Бичгийн дурсгалт зүйл

- а/Гэрэл, зураг, гэрэл зургийн хальс, гар зураг.
- б/Гар бичмэл, ном судар, бичиг баримт эх буюу хуулбар
- в/Үгүүлэл, дурдатгал, тэмдэглэл.

#### 2. Хөдөлмөрийн ба үйлдвэрийн багаж зэвсэгийн тухай.

а/Хотын урчууд, урлагийн мастерууд, нийгэм төрийн зүтгэлтэн, хөдөлмөрийн гарамгай хүмүүс, жирийн иргэдийн хэрэглэж байсан хөдөлмөрийн багаж зэвсэг, машин техник.

2. Улс, хоршоололын ба хувийн үйлдвэр худалдаа, тээвэр холбоо бөөл, гэгээрэл, нийгэм хангамжийн газруудад хэрэглэгдэж байсан машин техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл.

#### 3. Эд материал, соёлын дурсгалт зүйл.

а/Хувьсгалын өмнө ба хувьсгалаас хойш хотын иргэдийн хэрэглэж байсан гэр орон, түүний дотоод төхөөрөмж, хувцас хунар, гоёл шувууны зүйлүүд.



2.

б/Хотын урчууд, урлагийн мастеруудын хийсэн гар зураг, сийлбэр баримал, цутгамал, цоолбор, нэхмэл, наамал, хатгамал зэрэг ардын урлагийн төрөл бүрийн бүтээлүүд.

в/Уран барилгын өв уламжлалыг өөртөө хадгалсан барилга хашаа хэрмийн үлдэгдэл, чулуун сийлбэр, уран барилга ба хотын ерөнхий байдал зарим хэсгийг харуулсан зураг төсөл, загвар план зэрэг зүйлүүд.

г/Улс хоршоололын ба хувийн үйлдвэрийн гаргаж байсан элдэв төрлийн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан материал, бусад зүйлүүд.

Гурав. Музейд эд өлөг, түүх соёлын дурсгалт зүйлийг цугларуулах ба үнэлэх журам.

1. Хотын түүхэнд холбогдолтой эд өлөг, түүх соёлын дурсгалт зүйлсийг албан байгууллага, хамт олон ба ард иргэдээс зохих үнээр нь буруу үнэгүйгээр /бэлэглэлийн журмаар/ цугларуулна.

2. Бэлэглэлийн журмаар ирсэн зүйлүүдийг музейд түүх дурсгалын зүйл худалдаж авах комиссоос актаар хүлээн авч түүхийн чанарыг харгалзан үнэ тогтоож дансанд авна.

3. Худалдан авах зүйлийг музейд түүх дурсгалын зүйл худалдан авах комиссоос нэг бүрчилэн үзэж худалдан авах үнийг тогтоогоод улмаар дансны үнэ зохионо.

4. Музейн Г.Д.З. худалдан авах комиссоос эд өлөг, түүх соёлын дурсгалт зүйлийг худалдан авах үнийг тогтоохдоо дор дурдсан зүйлийг удирдлага болгоно Үүнд.

А. Хотын ба улсын түүхэнд хир зэрэг роль, ач холбогдолтойг анхаарах.

Б. Уг зүйлүүд одоо цаашдаа хир ховор болохыг харгалзах.

в. Хэрэгцээний өртөг буруу зах зээлийн ба улсын үнэтэй харьцуулах.

г/Уул зүйлийг худалдах эзний санал хүслийг харгалзах. Эдгээр болно. Харин дансны үнэ тогтоохдоо гагцхүү түүхийн ач холбогдол ба хэрэгцээний талыг үндэслэж тогтооно.



3:

5.Музейн Т.Д.З.худалдан авах комиссоос үнэ тогтоосон зүйлийг З хоногийн дотор музейн үзмэр буюу фондын зүйлийн дансанд бүртгэж эрдэм шинжилгээний тодорхойлолт картыг хөтлөн, зохистойгоор хадгалах буюу үэмэрт тавих ёстой.

6.Музейд Т.Д.З.худалдан авах комиссоос эд өлөг,түүх соёлын дурсгалт зүйлд үнэ тогтоохдоо мэрэгжлийн хүмүүсүүдийн зөвлөлгөөнийг авч,комиссын гишүүдийн олонхийн саналаар тогтоож, тусгай акт гарган гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.Худалдан авах зүйлүүдийг гарцхүү уг эздээс хүлээн авч, үнийг тэр эзэнд нь мөнгөөр өх бөгөөд төлөөний хүнээр дамжуулахыг хориглоно.

Дөрөв.Нийслэлийн түүх,шинэчлэн соёлын дурсгалт орон барилга,хөшөө дурсгалыг хамгаалах тухай.

1.Сайд нарын зөвлөлийн тогтоолоор улсын хамгаалалтанд авсан/хотын захиргаанд хариуцуулсан/ба хамгаалалтанд аваагүй боловч хотын түүхэнд онц холбогдолтой хөшөө,байшин,орон сав болон хөшөө дурсгалыг музейн дансанд авч үнэ тогтоон идэвхтэн хүмүүсээр хариуцуулна.

2.Нийслэлийн түүх соёлын дурсгалт байр орон,хөшөө дурсгалыг харгалзагчид нь уг зүйлүүдийг гаднын ямар нэгэн гэмтэлгүй бүрэн бүтнээр байлгах гол үүргийг гүйцэтгэж музейн захиргаанд тогтмол мэдээлж байж.

3.Нийслэлийн түүх соёлын дурсгалт байр орон,хөшөө дурсгалыг хагас жил дутамд нэгэн удаа музейн захиргаанаас шалган үзэж акт гаргаж байна.Харин түүхийн дурсгалт орон байр,хөшөө дурсгалд ямар нэгэн гэмтэл учруулсан байвал зохих эздийг олж акт тогтоон хууль ёсоор хохирлыг гаргуулах буюу хариуцлага хүлээлгэнэ.

ТАВ.ШАГНАЛ УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ.

1.Музейд эд өлөг,түүх соёлын дурсгалт зүйлүүдийг олноор худалдсан буюу үнэгүй бэлэглэсэн,онц чухал зүйлүүдийг олж сурвалжлаж өгсөн байгууллага,хамт олон ба хүмүүсийг жилд I удаа

4.

шалгаруулж музейн түүх дурсгалын зүйл худалдан авах комиссын шийдвэрээр мөнгөн ба эдийн шагнал олгоно.

2. Байгууллага, хамт олон ба хүмүүст олгох шагналыг музейд түүхийн дурсгалт зүйл худалдан авах төсвөөс олгох бөгөөд энэ нь 300-1500 төгрөгт багтаж байвал зохино.

3. Түүх соёлын дурсгалт орон барилга хөшөө дурсгалыг сайнаар харж хамгаалсан харгалзагчдад улирал дутамд 50-100 төгрөгийн шагналыг мөнхүү музейн төсвөөс гаргаж олгоно.

4. Урамшил шагналыг олгохдоо музейд ирүүлсэн зүйлийн түүхийн ач холбогдол ба уул зүйлүүдийн үнийн байдлыг харгалзан, музейн эрдэм шинжилгээний зөвлөлийн саналыг үндэслэж музейд түүхийн дурсгалт зүйл худалдан авах комиссоос эрхлэн олгоно.

5. Шагналд орсон хүмүүсийн зургийг сонинд нийтүүлэх зэргээр нийтэд сурталчлах ажлыг музейн захиргаанаас гүйцэтгэвэл зохино.

-----"-----

нийлсэн.....  
хянасан.....  
6% цо. Загджав.